МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр Дугаар 24/01 Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалт, “Монгол Даатгал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.1 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч батлагсугай.
2. 2024 онд Компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

МОНГОЛ УЛС МОНГОЛ ДААТГАЛ ХК 2032317 9019120961

Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990
www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр Дугаар 24 102 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.13 дахь заалт, "Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.5 дахь заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. "Монгол даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

МОНГОЛ УЛС
МОНГОЛ ДААТГАЛ ХК
2032317 9019120961

“Монгол Даатгал” ХК-ийн 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 24/02 тоот тогтоолын Хавсралт №01

## “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ТӨСӨВ

| № | Зардлын зүйл | Сарын цалин, ₮ | Нийт төсөв, ₮ |
|---|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн гишүүд | 660,000 | 31,680,000 |
| 2 | ТУЗ-ийн дэргэдэх хроoодын хурлын цалин | 100,000 | 3,200,000 |
| 3 | Эчнээ санал хураалтын цалин | 200,000 | 4,800,000 |
| 4 | ТУЗ-ийн хуралтай холбоотой бусад зардал | 3,000,000 | 3,000,000 |
| | **Нийт төсөв** | | **42,680,000** |

МОНГОЛ ДААТГАЛ ХК
2032317 Д.Д 9019120961

МОНГОЛ ДААТГАЛ

# МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр Дугаар 24103 Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
    1. Громов Сергей Борисович
    2. Огай Наталья Юрьевна
    3. Лхагважавын Төр-Од
    4. Лизуновагийн Таня
    5. Гантөмөрийн Ганжаргал
    6. Баяртогтохын Энхбаяр
3. Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
    1. Базарын Аюуш
    2. Зоригийн Хайдар
    3. Сиваев Александр Владимирович

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.

5. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛС МОНГОЛ ДААТГАЛ ХК 2032317 9019120961

ХУРЛЫН ДАРГА Б.АЮУШ

Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990
www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn